



Монголын Эмэгтэйчүүдийн Сан
/МОНЭС/



МУИС-ийн Нийгмийн
Шинжлэх Ухааны Сургууль

**ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН
ХЭРЭГСЛЭЭР САДАР САМУУНЫГ
СУРТАЛЧИЛЖ БҮЙ ӨНӨӨГИЙН
БАЙДАЛ**

Тандалтын судалгааны хураангуй

Улаанбаатар 2007



Монголын Эмэгтэйчүүдийн Сан
/МОНЭС/



МУИС-ийн
Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль

**ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛЭЭР
САДАР САМУУНЫГ СУРТАЛЧИЛЖ БҮЙ
ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ХИЙСЭН
ТАНДАЛТЫН СУДАЛГААНЫ
ХУРААНГУЙ**

Судалгааны санхүүжүүлэгч: Монголын Эмэгтэйчүүдийн Сан /МОНЭС/

Судалгааны хэрэгжүүлэгч: МУИС-ийн
Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль

Монгол улс зах зээлийн харилцаанд шилжсэнээс хойш даруй 17 жил өнгөрөхөд нийгэмд янз бүрийн сөрөг үзэгдлүүд, анхаарал татсан асуудлууд олон гарах болсон. Үүний нэг нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдаж байгаа охид, эмэгтэйчүүдийг садар самуунд уруу татсан мэдээлэл, сурталчилгаа гэж үзэж болно.

1998 онд батлагдан гарсан Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулинд садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, кино, дүрс бичлэг, бусад зүйлийг бэлтгэх, тараах, борлуулах, хадгалахыг хориглосон байдаг. Бодит байдалд хэвлэл мэдээлэл нь садар самууны хор уршгийг олон нийтэд ойлгуулан таниулах, бэлгийн халдварт болон дархлалын олдмол хомсдол өвчнөөс урьдчилан сэргийлэх сурталчилгаа явуулах үүрэгтэй хирнээ үүнийгээ хангалтгүй биелүүлж байна.

Монголын Эмэгтэйчүүдийн Сан /МОНЭС/ “Охид эмэгтэйчүүдийг садар самуунд уруу татах сурталчилгааг зогсооё” сэдвээр 2006 оны 12 дугаар сарын 10-наас 2007 оны 03 дугаар сарын 08-ныг хооронд 88 хоногийн сан бүрдүүлэх кампанит ажлыг зохион байгуулсан юм. Энэхүү кампанит ажилд 483 хувь хүн, 34 байгууллага оролцож 2 689 600 төгрөгийн сан бүрдүүлсэн ба энэхүү хандивыг охид, эмэгтэйчүүдийг садар самуунд уруу татаж байгаа мэдээлэл, сурталчилгаанд дүн шинжилгээ хийх, энэ чиглэлээр гарсан хуулиудын хэрэгжилт хэрхэн хангагдаж байгааг тодруулах тандалтын судалгаа хийхэд зориулсан юм.

Судалгааг хийж гүйцэтгэсэн МУИС-ийн Нийгмийн шинжлэх ухааны сургуулийн Социологи, Нийгмийн ажлын тэнхмийн багш С.Нарантуяа, Т.Бүрэнжаргал, Д.Оюунцэцэг нарт гүн талархал илэрхийлье.

Судалгааны арга зүй

Судалгааны онцлогтой холбогдуулан баримт бичгийн болон ажиглалтын аргыг сонгон авч түлхүүр асуулт бүхий тэмдэглэл, хүснэгтийг бэлтгэн судалгаанд ашиглалаа. Мэдээллийн хэрэгслийг судалгааны судлагдахуун болгоходоо мэдээллийн агуулга, хандлага, нэвтрүүлгийн

хэлбэр, мэдээллийн эзлэх хэмжээ, давтамж, мэдээлэл байршсан нүүр, мэдээллийн төрөл, тулгуурласан баримт, гаралтын тоо, хүрээ болон нэвтрүүлгийн цаг, эх сурвалжийн төлөөлөл зэрэг шинжилгээний үзүүлэлтүүдийг сонгон авч тухайн мэдээллийн хэрэгслийн онцлогийг харгалзан үзсэн болно.

Судалгаанд өдөр тутмын сонин, чөлөөт хэвлэл тус бүр нэгийг сонгон 2007 оны 1, 4, 7, 10 сарын дугааруудын мэдээлэл, орон даяар нэвтрүүлгээ цацдаг нэг телевиз, Улаанбаатар хотод нэвтрүүлгээ цацдаг хоёр телевиз болон телевизүүдийн "Чат" сувгууд, Улаанбаатар хотод цацагддаг богино долгионы FM-ийн радио хоёрыг сонгож, тус бүр нэг сарын мэдээлэлд нь дүн шинжилгээ хийсэн юм.

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр садар самууныг сурталчилж байгаа байдлыг судлахдаа *нэгдүгээрт*, садар самууныг сурталчилж буй мэдээллийн агуулга, хандлага, хэлбэрийг бүхий л талаас нь тандан судлах, *хоёрдугаарт*, садар самууныг сурталчилж буй хэвлэл мэдээллийн хэрэгслийн нийтлэлийн бодлогод нөлөөлөх, *гуравдугаарт*, садар самуун явдалтай тэмцэх тухай хууль болон бусад эрх зүйн зохицуулалтын хэрэгжилт хангагдаж байгаа эсхийг тодруулсан юм.

САДАР САМУУНТАЙ ТЭМЦЭХ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Улсын Их Хурлаас “Садар самуун явдалтай тэмцэх тухай” бие даасан хуулийг 1998 онд батлан гаргасан байна. Энэхүү хууль нь 4 бүлэг, 14 зүйлтэй бөгөөд хуулийн зорилт буюу хуулиар зохицуулах харилцааг садар самууныг сурталчлах, биеэ үнэлж, явалдахтай тэмцэх болон эротик сурталчилгаа, үйлчилгээг журамлахаар заасан байна. Садар самуун гэдэг ойлголтыг дараах байдлаар тодорхойлсон байна.

1. “садар самууныг сурталчлах” гэж бэлгийн дур хүслийг өдөөх зорилгоор хурьцал үйлдэхийг болон хүний бэлэг эрхтнийг илтээр хэвлэл, ном зохиол, кино, дүрс, дуу авианы бичлэг болон бусад хэлбэрээр уншуулах, сонсгох, үзүүлэхийг;
2. “эротик” гэж гоо сайхны таашаал төрүүлэх зорилгоор хүний нүцгэн биеийг урлаг, уран сайхны хэлбэрээр үзүүлэхийг тус тус ойлгож хэрэглэхээр тодорхойлсон байна.

Энэ хуулиар садар самуунаас урьдчилан сэргийлэх болон хууль бус үйлдлийг зогсоох хэм хэмжээг авч үзжээ.

Садар самуун үйлдлийг хориглож урьдчилан сэргийлэхийн тулд садар самууныг аливаа хэлбэрээр нийтэд түгээж дэлгэрүүлэхгүй байх, ялангуяа насанд хүрээгүй хүүхдийг ийм үйл ажиллагаанд уруу татагдахаас сэргийлэх арга хэмжээ, үйл ажиллагааг хуулиар шууд хориглох, зарим үйл ажиллагааг зөвшөөрөлтэй эрхлэх, орон зайгаар хязгаарлах, шаардлага, нөхцөл тавих зэрэг хэлбэрээр хэрэгжүүлэхээр тохирсон байна.

Энэ хуулиар эротик буюу уран сайхан урлаг соёлын талаас үзүүлэх үзүүлбэр, ном, зохиол, зураг, кино дүрс бичлэгийг зөвшөөрсөн хэмжээнд үзүүлэх, бэлтгэх, түгээхийг хуульчлан зааснаар хууль болон хууль бус үйл ажиллагааны зааг ялгааг тодорхой болгосон байна.

Хууль бус үйлдлийг таслан зогсоох зорилтын хүрээнд хууль зөрчсөн этгээдэд мөнгөн торгууль ноогдуулах, зарим үйл ажиллагааг зогсоох, хувь хүнийг баривчлах, хорих зэрэг захиргааны болон эрүүгийн хариуцлага хүлээлгэх замаар хэрэгжүүлэхээр тусгагдсан байна.

“Садар самуунтай тэмцэх тухай” хуулинд бусад хуулиудад төдийлөн тусгагдаад байдаггүй нэг онцлог харилцааг тусгасан байна. Тухайлбал, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр садар самууныг сурталчилсан, мөн садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлийг бэлтгэх, тараах, борлуулах, энэ зорилгоор хадгалсан

зөрчлийг нэг жилийн дотор давтан гаргасан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан байна.

Энэхүү бие даасан хуулиас гадна Эрүүгийн хууль, Зар сурталчилгааны тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Захиргааны хариуцлагын тухай зэрэг хуульд зарим зохицуулалтыг тусгасан байна.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд садар самуун явдлыг зохион байгуулах, түүнийг аливаа хэлбэрээр дэмжих аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхийг хориглосон. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын нутаг дэвсгэрт ийм үйл ажиллагаа явуулахыг шууд хорьсон байна.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд тус улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэнд садар самууныг сурталчлах, түгээн дэлгэрүүлэхийг хориглодог байна.

Зар сурталчилгааны тухай хуульд садар самуунд уруу татахад хүргэж болох агуулгатай зар сурталчилгааг бүтээх, түгээхийг хориглодог.

Захиргааны хариуцлагын тухай хуулийн 41 дүгээр зүйлд садар самууныг сурталчилсан, түүнчлэн өнгөний өвчний үзлэг, эмчилгээнээс зайлсхийсэн, эмчилгээг тасалсан, өнгөний өвчин халдаагчаа нуун дарагдуулсан бол 10000 хүртэл төгрөгийн торгууль ногдуулахаар заасан.

Олон нийтийн радио, телевизийн тухай хуулиар садар самууныг сурталчилсан агуулгатай нэвтрүүлэг бэлтгэж, түгээхийг, Соёлын тухай хуулиар садар самууныг сурталчилсан соёлын үйл ажиллагааг явуулахыг тус тус хориглосон байна.

Садар самуунтай тэмцэх тухай асуудлыг гарч байгаа хуулиудад тусгаж, түүнийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг тодорхой тусгасан байдаг боловч хуулийн хэрэгжилт хангалтгүй, хэрэгжилтэд хяналт тавьдаггүй, садар самууныг сурталчилж байгаа хэвлэл мэдээллийн хэрэгслүүд садар самууныг сурталчилснаар ямар нэгэн хариуцлага хүлээх механизм өнөөдрийг хүртэл бий болоогүй байна.

Садар самуунтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлээр хэвлэл, мэдээллийн хэрэгслээр садар самууныг сурталчлахыг болон садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлийг бэлтгэх, тараах, борлуулах, энэ зорилгоор хадгалах, ийм төрлийн зүйлийг хилээр нэвтрүүлэхийг тус тус хоригложээ.

Олон нийтэд зориулсан хэвлэл мэдээллийн зарим хэрэгслийн нийтлэл, нэвтрүүлэг, зар сурталчилгаанд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр садар самуунтай тэмцэх хууль эрх зүйн орчин бүрдсэн хэдий ч түүний хэрэгжилтийг ханах, хэрэгжүүлэх механизм тодорхойгүй байна гэсэн дүгнэлтийг судалгааны багийнхан хийж байна.

Садар самуунтай тэмцэх хуулиар зохицуулж буй эрх зүйн харилцаа нь нийгмийн болоод хүний хөгжил /ухамсар, төлөвшил, орчин, орлогын эх үүсвэр гэх мэт/ хүчин зүйлээс хамаардаг нийгмийн харилцаа юм. Уг харилцаа нь нийгмийн хөгжлийг дагаад өөрчлөгдөж байдаг учир энэ талаар гарсан хуулиудыг хэрэгжүүлэх, хяналт тавих механизмыг тодорхой болгох хэрэгцээ байгааг судалгааны үр дүн харуулсан юм.

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ БА САДАР САМУУНЫ ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

1. СОНИН


Хэвлэл мэдээллийн хэрэгслээр садар самууныг сурталчилж байгаа байдлыг садар самууныг сурталчилж буй мэдээллийн агуулга, хандлага, нэвтрүүлгийн хэлбэр, мэдээллийн эзлэх хэмжээ, давтамж, мэдээллийн байршсан нүүр, мэдээллийн төрөл, тулгуурласан баримт, эх сурвалжийн төлөөллийг тандан илрүүлэхийг зорьсон билээ. Энэ зорилгоор өдөр тутам хэвлэгдэн гардаг “Өдрийн сонин”, чөлөөт хэвлэлээс “Хүмүүс” сонин, тусгай хэрэгцээт сониноос “Маш нууц” сонины нийтлэлийн агуулгад дүн шинжилгээ хийсэн юм.

Өдөр тутмын сонины нэг сард гарах дугаарын тоо хамгийн их буюу 25 удаа гардаг ч, садар самуунтай холбогдол бүхий мэдээлэл 0.01%-ийг эзэлж байхад, гаралтын тоогоор хамгийн бага тусгай хэрэгцээт сонин нь нийт мэдээллийнхээ 10.7%-ийг энэ төрлийн мэдээлэлд зориулдаг. Уг сонин нь нийт мэдээллийн талбайгаараа чөлөөт сонинтой бараг адилхан ч, 17,8 дахин их садар самуунтай холбоотой мэдээллийг нийтэлж, 15,5 дахин том талбайг эзэлсэн байна.

Хамгийн бага талбайтай нь өдөр тутмын сонин бөгөөд тусгай хэрэгцээт сониноос 35,2 дахин бага талбайд мэдээллийг нийтэлсэн байна.

Дүрс зураг 1.

Садар самуунтай холбогдсон мэдээлэл сонин тус бүрээр



Хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдаж байгаа мэдээллүүдийг агуулгаар нь энгийн, садар самуунаас урьдчилан сэргийлэх, садар самуунтай холбогдолтой танин мэдэхүйн, садар самууны тухай асуудлыг хөндсөн, зар сурталчилгааны мэдээ гэж ангилан судалж үзлээ.

Сониуудад бичигдсэн **Энгийн мэдээлэл** нь ямар нэгэн асуудал хөндөөгүй, хэн нэгэн субъектэд хандаагүй, их бага хэмжээгээр садар самуун үг хэллэг, зураг нийтэлснийг авч үзэж байна. Энгийн мэдээллүүд нь үр өгөөж багатай танин мэдэхүйн талаасаа ч уншигчдын сонирхлыг татахгүй мэдээллүүд байна.

Сэрэмжлүүлсэн мэдээлэл нь хүчингийн хэрэг, садар самуун үг хэллэг, зураг хөрөг ашиглан уншигчдад сэрэмжлүүлэг өгөх, болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх тухай мэдээлэл нийтлэгдсэн эсэхийг судлан үзэхэд нийт мэдээллийн 22,7% нь сэрэмжлүүлгийн чанартай мэдээлэл байна. Ийм төрлийн мэдээллийн 60 орчим хувийг хүчингийн хэргийн тухай мэдээлэл эзэлж байна. Гэхдээ дээрх мэдээллийг олон нийтэд танилцуулахдаа хэт илэн далангүй бичсэн мэдээллүүд эзэлж байлаа.

Шигтгээ: Согтуу эрэгтэйчүүд нэгнийгээ хүчиндэн дээрэмдсэн. Мөн тохуурхан доромжилж бэлгийн дур хүслээ ёс бусаар хангаж бөгс рүү нь шил хийчихье гэж ярьж байжээ.

/Хүмүүс. 2007.04.06 NN#13/

...Манай эцэг эхчүүд бага насны охиддоо их хайхрамжгүй хандах юмаа. Үүнд би их сэтгэл зовнидог хүн. Тэгээд ч бага ч гэсэн эцэг эхэд анхааруулах үүднээс өөрт тохиолдсон зовлонгоо хуваалцах гэсэн юм. Одоо 30 настай эмэгтэй 1-р ангийн жаахан охин байхдаа хүчиндүүлж, хүүхэд гаргах хувьгүй болжээ.

*/Маш нууц. 2006. NN#27 Нийтлэлийн нэр: Охинтой хүн онцлон
уншаарай, шүлэнгэтсэн харц/*

Садар самууны холбогдолтой танин мэдэхүйн мэдээлэл нь уншигчдад сонирхуулах үүднээс статистик болон судалгааны тоо баримт дурьдахдаа садар самуун үг хэллэг, зураг хөрөг ашигласан мэдээллүүдийг багтаасан. Нийт мэдээллийн 15% нь танин мэдэхүйн чанартай мэдээлэл байна. Бэлгийн амьдралын тухай өгүүлэхдээ садар самуун үг хэллэгийг ихээр ашиглаж дүрсэлсэн болон тоо баримтад тулгуурлан тайлбарлах оролдлого хийсэн мэдээллүүд орсон байна.

Асуудал хөндсөн мэдээлэл нь тодорхой нэг асуудлыг хөндөж нийтлэл болон баримтыг дурьдахдаа садар самуун үг хэллэг, зураг ашиглан нийтлэхийг зорьсон байна. Нийт мэдээллийн 39,4% нь асуудал

хөндсөн мэдээлэл байсан. Агуулгаар нь авч үзэхэд биеэ үнэлэх янз бүрийн орчин нөхцөл бүрдэж байгаатай холбоотой нийгмийн асуудал гарч ирээд байгааг ихээр өгүүлсэн ч хэтэрхий ил задгай байдалтай бичсэн нийтлэл их байна.

Зар сурталчилгааны мэдээллүүдэд садар самууны тухай ил тод зураг байхгүй ч хүний зүс, өнгө мөнгө заан, ажил санал болгох зар нэлээд их нийтлэгддэг. Эдгээр зар “Ажлын зар” гэсэн ангилалд багтаж явдаг байна. Зар сурталчилгааны мэдээлэлд садар самууныг илт сурталчилсан зар байхгүй ч дээр дурьдагдсан далд сурталчилгаа зонхилж байна. Энэ талаар ямар нэгэн хариуцлага хүлээлгэх заалт хуульд байхгүй учир хэвлэл мэдээллийн хэрэгслээр садар самууныг сурталчлах хуульд нэмэлт өөрчлөлт оруулахад анхаарах хэрэгтэй гэсэн дүгнэлтийг хийж байна.


2. ТЕЛЕВИЗ

2007 оны байдлаар манайд орон даяар гардаг 5 телевиз, кабелийн олон арван суваг, нийслэлийн хэмжээнд гардаг 15 телевизийн суваг / ТВ5-2, MN25-2, UBS-2 эдгээрийг оруулаад/ нэвтрүүлгээ цацаж байна. Телевизээр цацагдаж буй мэдээллийг мэдээ, сурвалжлага, танин мэдэхүй, ярилцлага, цэнгээнт шоу, зураг, кино, хэлэлцүүлэг, эрэн сурвалжилсан, зар, жүжиг зохиол, урлагийн тоглолт гэсэн төрлүүдэд хуваан үзлээ. Уг мэдээллүүдийн тулгуурласан баримт, эх сурвалжийг авч үзвэл 100% ишлэл ярианд тулгуурласан байна. Үүнээс 25% нь мэдээ, 25% нь ярилцлага хэлбэрээр олон нийтэд цацагдсан бол, цэнгээнт шоу хэлбэрээр буюу реалити нэвтрүүлгээр 50% нь тус тус цацагдсан байна. Дээрх мэдээллүүд нь нийтлэл, нэвтрүүлгийн чухал шинж болох статистик тоо баримт, судалгааны материалд тулгуурлалгүй мэдээллээ олон нийтэд цацаж байна. Нийт мэдээлэл, нэвтрүүлгийг эх сурвалжийн хувьд нь авч үзвэл, 25% нь дотоодын мэдээлэл, 75%-ийг гадаадын мэдээллээс иш татсан байна.

Телевизэд ажиглалт хийсэн сарын хугацаанд орон даяар нэвтрүүлгээ цацдаг ТВ-ээр садар самууныг сурталчилсан, садар самууны талаарх мэдээлэл гараагүй болно. Харин Улаанбаатар хотод нэвтрүүлгээ цацдаг 2 телевиз болон “Чат” сувгаар нийт 254 цагийн садар самууны тухай нэвтрүүлэг

Дүрс зураг 2.

ТВ “чат” суваг болон 2 телевизийн мэдээлэл:



цацагдсан байна. Үүнийг телевиз тус бүрээр авч үзвэл, садар самууны талаарх мэдээллийг хамгийн их цацсан телевиз нь ТВ-ийн “чат”-ын суваг юм.

Сонгон авсан С1, ТВ8 телевизээр 28 цаг буюу нийт мэдээллийнх нь 11,02%-ийг садар самууны тухай нэвтрүүлэг эзэлж байна. Сонгож авсан телевизүүдийн мэдээлэл давхардаагүй бөгөөд С1 телевизээр гарсан нийт мэдээллийн 25%-ийг энгийн мэдээлэл, 33,3%-ийг танин мэдэхүйн мэдээлэл, 16,6%-ийг реалити шоу, 25%-ийг зөвлөгөө эзэлж байна. Харин ТВ8 телевиз хамгийн их буюу 97,9% садар самууныг сурталчилсан мэдээллийг гаргасан байна. Үүнээс гадна ТВ8 телевиз 1 удаа буюу 1,04% сэрэмжлүүлэх мэдээлэл, мөн 1 удаа буюу 1,04% нь садар самуун явдлын талаар асуудал хөндсөн мэдээллийг олон нийтэд цацжээ.

Хүснэгт-1. Телевизүүдийн нэвтрүүлэгт хийсэн дүн шинжилгээ

Телевизийн нэр	Нэвтрүүлгийн нэр	Хэмжээ /цаг/	Хувь
МҮОНТВ	“Цагийн хурд” “Гэрэлтэй цонх”	-	-
С1	“Диваажингийн зочид буудал” “Өдөн дэр”	4	1,57%
ТВ8	“Хөшиг” шөнийн сурвалжлага ТВ чат	24 2	9,44% 0,78%
Нийт		224	88,18%
		254	100%

Дээрхээс үзэхэд С1 телевиз сексийн талаар танин мэдэхүйн болон зөвлөгөөг түлхүү бэлтгэж гаргадаг бол, ТВ8 телевиз нь садар самууныг сурталчилсан зарыг /ТВ-ийн чатаар/ маш ихээр гаргаж байгаа нь бидний ажиглалтын судалгаанаас харагдсан болно.

3. FM РАДИО

Монгол улсын хэмжээнд нийт 50 FM радио үйл ажиллагаагаа явуулж байгаагаас Улаанбаатар хотод 18 FM радио нэвтрүүлгээ цацдаг байна. Үүнээс 2 буюу “Life 104” болон “Инээмсэглэл 99,3” FM радиог сонгон авч мэдээллийн агуулгад садар самуун явдлыг сурталчилж буй эсэхэд дүн шинжилгээ хийсэн. Энэ хугацаанд “Инээмсэглэл 99,3” FM-ийн нэвтрүүлгийн агуулгад садар самууныг сурталчилсан шинжтэй ямар ч мэдээлэл илрээгүй боловч “Life 104” FM-ийн нэвтрүүлгүүдэд садар самууныг сурталчилсан мэдээлэл үлэмж их байсан. Тиймээс “Life 104” FM-ийн нэвтрүүлгийн агуулгад дэлгэрэнгүй дүн шинжилгээ хийсэн болно.

Мэдээллийг нэг өдөр алгасах байдалтайгаар тэмдэглэхэд 15 өдөрт садар самуун явдлыг сурталчилсан давтамжгүйгээр нийт 39 мэдээлэл тэмдэглэгдсэн байна. Эдгээр мэдээлэл нь статистик тоо баримт, тухайн нэг мэдээллийн үргэлжлэх хугацаа, давтамж нь тодорхой бус бөгөөд мэдээллийн төрөл хэлбэрээс шууд хамааралтай байна. Өөрөөр хэлбэл, ямар насны, ямар хүйсийн хүн нэвтрүүлэгт холбогдохоос хөтлөгчийн яриа, хандлага өөрчлөгдөж, түүний оролцогчидод тавьж буй асуултууд тухайн нөхцөл байдлаасаа хамааран дахин давтагдах боломжгүй байдаг ажиглалт судалгаанаас харагдлаа. FM –ийн хөтлөгч нь сонсогчтой харилцахдаа ямар нэгэн баримтад тулгуурлаагүй, аль нэг мэдээ сурвалжлага, танин мэдэхүйн шинж чанартай мэдээллүүд биш зөвхөн хөтлөгчийн зүгээс FM-ийн сонсогчид хандсан яриа, мэдээлэл, шторк¹ оролцогчидтой ярилцсан ярилцлага, зар сурталчилгааны мэдээлэл зэрэг болно. Эрэгтэй хөтлөгч нэвтрүүлгээ явуулж байх үедээ садар самуун өнгө аястай, ёс суртахуунгүй үг хэллэгийг байнга хэрэглэн оролцогчидтой ярилцаж, ямар ч дууны захиалгыг хязгаарлалтгүйгээр авч цацдаг байна. Тухайлбал, утсаар холбогдсон эмэгтэй оролцогчдыг “янагхан минь, хонгор минь” гэх мэтээр дуудах нь байнга давтагдана.

Шигтгээ: FM радиогийн хөтлөгч эрэгтэй оролцогчоос асууж байгаа асуулт: “Чи нэг эрэгтэй, 2 эмэгтэйтэй гурвуулаа секс хийж үзсэн үү? Мөнгө, хайр, секс гурвын алийг нь илүүд үздэг вэ? Чи хамгийн сүүлд хэзээ секс хийсэн бэ? Найз залуутайгаа юу? Эсвэл зуурдын хүнтэй юу?”

2007.07.25

Хөтлөгчийн ийнхүү садар самуун, ёс суртахуунгүй үг хэллэг хэрэглэж байгаа нь өсвөр үе залуучуудын хүмүүжилд сөргөөр нөлөөлөх хүчин зүйл болж байна. Учир нь FM радиогийн нэвтрүүлэгт холбогдсон оролцогчдын 91% нь өсвөр үе буюу 14-18 насныхан байдаг нь судалгааны явцад ажиглагдлаа. FM радиод холбогдож буй сонсогчдын хүйсийг аваад үзвэл 60,5% нь эмэгтэй, 39,5% нь эрэгтэй байна. Хөтлөгчийн зүгээс гарсан садар самуун үг ярианд оролцогчид хандахдаа асуусан асуултанд хариулж тухайн садар самуун өнгө аястай яриад дэмжин ярилцаж байсан. Өөрөөр хэлбэл, дургүйцсэн, татгалзсан, эвгүйцсэн хандлага гаргахгүй байгаа нь сонирхол татаж байлаа.

Мэдээллийн төрөл


Сонинд нийтлэгдэж байгаа мэдээлэл, нийтлэл, өгүүлэл зэрэг хамгийн өндөр хувьтай байгаа мэдээллийн төрөлд анализ хийхэд:

- 18,1% нь судалгааны материалд,
- 13,6% нь ажиглалтанд, 6,1% нь ишлэл ярианд,
- 3,0% нь статистик тоо баримтанд тус тус тулгуурласан байна.

Нийтлэл өгүүллийн ишлэл ярианд тулгуурласан хувь нь бусадтай харьцуулахад хамгийн өндөр буюу 22.7%, нийт судалгаанд орсон сонинуудын хувьд ч ишлэл яриа маш өндөр буюу 36%, байна. Харин ажиглалтад тулгуурлан бичигдсэн нь хамгийн өндөр буюу 37.8 хувьтай байгаа нь статистик баримтад тулгуурласнаас 47 дахин, судалгааны материалд тулгуурлан бичигдсэнээс 1,5 дахин илүү байгаа нь мэдээллийг баталгаатай эх сурвалжаас авсан, мэдээллийн найдвартай байдал гэдгийг анхааралдаа авсан эсэхэд эргэлзээ төрж байсан юм. Мэдээлэл нь баталгаагүй, хэтэрхий задгай, эрээ цээргүй үг хэллэг бүдүүлэг дүрслэлийг агуулж байсан.

Сонины садар самуунтай холбоотой мэдээллийн 57,5% нь дотоодынх, 15% нь Орос, 16% нь АНУ, Хятад, Англи зэрэг улсын орчуулгын материалууд эзэлдэг байна.

Дүрс зураг 3.
Сонины садар самуун мэдээллийн төрөл:



Мэдээллүүд нь ямар агуулгатайгаар сонинд нийтлэгдсэнийг садар самуун үг хэллэг, үнсэлцэх озолцох үйлдэл, нүцгэн биеийн зураг, хурьцал үйлдэх үйл явцыг тоочсон эсэх зэрэг шалгуурын тусламжтайгаар, судалгаа хийгдсэн 3 сонинд ямар байгаад дүн шинжилгээ хийсэн. Садар самууны холбогдолтой нийт мэдээллийн 48% нь бие эрхтнээ ил гаргасан хүүхний зураг нийтэлсэн бол, хурьцал үйлдэх болон үнсэлцэх озолцох үйлдлийн талаар, бэлгийн амьдралын талаар маш нарийн дүрсэлсэн байна.


TV-ийн судалгаанаас үзэхэд нийт мэдээллийн дийлэнх буюу 87,2%-ыг садар самууныг ямар нэгэн байдлаар сурталчилсан мэдээлэл гарсан байна. Хурьцал үйлдэхийг ярьсан мэдээлэл 96%, садар самуун үг хэллэгийг ашигласан мэдээлэл 98,9%тай байгаа нь олон нийтийн мэдээллийн чухал хэрэгсэл болох телевизээр садар самуун үг хэллэг ашигласан, сурталчилсан мэдээллүүд их гарч байгааг харуулж байна. Тухайн сонгож авсан нэвтрүүлгүүдээс гадна телевизүүдээр гарч байгаа уран сайхны киногоор садар самууныг сурталчилсан, үзүүлсэн маш олон үйлдэл гарч байна. Гэтэл садар самуун явдлын талаар сэрэмжлүүлсэн

мэдээлэл дөнгөж 0,9%-ийг эзэлж байна. Танин мэдэхүйн мэдээлэл 3,63%, садар самуун явдлын талаар асуудал хөндсөн мэдээлэл 0,9%ийг эзэлж байна. Садар самуун байдлын шууд хэлбэр болох хурьцал үйлдэхийг ярьсан мэдээлэл зар сурталчилгааны 96%-ийг эзэлж байсан нь гайхшрал төрүүлж байсан.

FM-ийн нийт давтамжгүйгээр тэмдэглэгдсэн садар самуун явдлыг сурталчилсан 39 мэдээллийг бүлэглээд үзвэл энгийн мэдээлэл 21 буюу нийт мэдээллийн 53,8%, зар сурталчилгааны мэдээлэл 6 буюу 15,4 %, сэрэмжлүүлэх мэдээлэл 2 буюу 5,1%, асуудал хөндсөн мэдээлэл 2 буюу 5,1 %, танин мэдэхүйн мэдээлэл 1 удаа 2,5 %, 7 шторк буюу 17,9% гэж тэмдэглэгджээ.

Дүрс зураг 4.

FM-ийн зар сурталчилгааны агуулга:



Үүнээс харахад энгийн мэдээлэл нь нийт мэдээллийн талаас илүү хувийг эзэлж байгаа нь FM-ийн энгийн мэдээллийн агуулга, хэлбэрт садар самуун явдлыг сурталчилж байгаа мэдээлэл ихээр агуулагдаж байна. FM нь бусад хэвлэл мэдээллийн хэрэгслийг бодвол зөвхөн сонсох буюу дан яриа, ярилцлага, дуу, зар сурталчилгаа явуулах байдлаар сонсогчдод хүрдэг учраас энэ нь нэг талаас хөтлөгчийн нүүр царай ил харагддаггүйгээс ичгүүр сонжуургүй, ёс зүйгүй зүйл ярих, асуух явдалд санаа зовохоо больсон байна.

Нөгөө талаас зарим FM-ийн мэдээллийн агуулга, хэлбэрт болон хөтлөгчийн ёс зүйд ямар ч хяналт тавьдаггүй нь харагдаж байна. Энгийн мэдээллийн дараа FM-ийн Шторк /FM,

Эрүүгийн хуулийн 123 дугаар зүйл /Садар самууныг сурталчлах/-д зааснаар садар самууныг сурталчилсан хэвлэл, ном, зохиол зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлсийг бэлтгэсэн, тараасан, борлуулсан, нийтэд үзүүлсэн, энэ зорилгоор улсын хилээр нэвтрүүлсэн бол эрүүгийн гэмт хэрэгт тооцож хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 3 сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэх, энэ хэрэгт 16 нас хүрээгүй хүнийг татан оролцуулсан тохиолдолд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 71-ээс 100 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэхээр заасан байна.

радиоогоор цацагдаж буй өмнө бэлтгэгдсэн богино хэмжээний дуу, яриа, хошигнол/ 17,9%-ийг эзэлж байна. Судалгаа хийсэн нэг сарын хугацаанд садар самууныг сурталчилсан нийт 7 төрлийн шторк 93 удаагийн давтамжтайгаар цацагдсан байна. Шторкууд нь давтамжтайгаар цацагдахад нийт мэдээллийн бүтцэд эзлэх хувийн жин нэмэгдсэн. Тухайлбал, 7 төрлийн шторк 17,9%-ийг эзэлж байснаа давтамжтайгаар цацагдан 57,8% болтол өссөн байна. Цацагдаж байгаа шторкнуудын утга агуулга, үг хэллэг, ая зэрэг нь садар самуун шинж чанартай байгаад зогсохгүй эвгүй дуу авиаг түлхүү оруулж өгсөн байдаг.

Мэдээллийн агуулга

Сонинд гарч байгаа зар сурталчилгааны мэдээлэлд анализ хийхэд садар самууны хуульд заасанчлан ил тод зураг хөрөг байхгүй ч, хүний царай зүс, өнгө мөнгө заан ажил санал болгох зар нилээд их нийтлэгддэг. Гэхдээ энэ нь сурталчилгаа хийгээгүй, хүний бэлгийн дур хүслийг өдөөгөөгүй зүгээр л "Ажлын зар" гэдэг ангилалд багтаж явдаг байна.

Өндөр царайлаг охидыг саунд массажистаар ажилд авна. Утас: 9909....

Мини баар, саунд царайлаг охидыг массажистаар авна. Жич: Царайлаг шүү. Утас:9665....

Нэг оройг хамт өнгөрүүлэх залуутай танилцана. Санхүүгийн туслалцаа үзүүлэх хүнтэй дотно танилцана. Утас:9987...

Иймэрхүү зараар ажилд орон хохирол амссан олон хэргүүд манайд сүүлийн үед ихээр яригдаж байгаа. Өөрийн хүсэл сонирхлоор уг ажилд орон ажил хийсэн, хэн ч түүнийг албадаагүй гэсэн ажил олгогчдын байр суурь нь тэдний эрх ашгийг хамгаалахад саад болдог. Мөн олон төрлийн зар явах болсны нэг нь "Танилцъя" зар. Үүнд: "Нэг оройг хамт өнгөрүүлэх залуутай танилцъя, өнөө орой шоудах охин хайж байна, санхүүгийн туслалцаа үзүүлэх хүнтэй дотно танилцана" гэсэн зарууд байдаг нь хэвийн үзэгдэл болчихсон байна. Энэ нь гэмт этгээдүүдэд шунал сэдлийн ихээхэн таатай боломж олгож байна. Бэлгийн амьдралын талаарх мэдлэг болохуйц мэдээллийг зөв өнгө аястайгаар өгөх шаардлага байгааг судалгаа явагдсан гурван сонины аль алинд нь ажиглагдлаа.

Өнөөдөр Улаанбаатар хотод нэвтрүүлгээ цацаж байгаа 15 телевизийн 7 нь ТВ "Чат" сувгийг 2007 оноос эхлэн ажиллуулж байна. ТВ-ийн "чат"-ын нэг суваг нь нийт 226 цаг буюу өөрийн сувгаар цацаж буй бүх мэдээллийн 88,9%-ийг садар самуунд уруу татсан мэдээлэл эзэлж байсан. Телевизийн "чат"-уудаар шөнө, өдөргүй үргэлжлэх эцэс төгсгөлгүй хөвөрсөн зар явах нь өнөөдөр нэгэнт энгийн үзэгдэл болжээ.

ТВ “чат” нь садар самууныг сурталчилж байгаа нэгэн эх сурвалж болж байгааг хэлэхийн сацуу ТВ “чат” нэвтрүүлэг тухайн телевизийн санхүүгийн боломжоо зузаатгах нэг гол суваг шижим нь болж байна.

Шигтгээ:

9967.... 24-тэй залуу байна. Янхан авна. Тохиролцоно.

9996.... Яг одоо 16-18 насны охидтой шоудъяа, сексдье, яг одоо залга, 18 настай 2 банди

9908....Царайлаг, тачаангуй, групплэж чадах 2 охинтой танилцана. Санхүүгээр тусална.

9938... Энэ дугаар луу залга. Үнэгүй явдаг 2 охин байна уу?

9994...14-тэй банди секс хийхийг хүсч байна.10-ыг өгье.

ТВ-ийн “чат”-ын нэвтрүүлэг нь өдөр бүр гардаг бөгөөд өдөр, орой гэсэн байдлаар өдөрт дунджаар 8 цаг орчим гардаг. Үүнээс өдрийн 13-15, шөнийн 01-03 цагуудыг сонгосон. ТВ8-ийн “чат” нэвтрүүлэгт оролцож буй оролцогчдыг насны байдлаар авч Үзвэл 14-24 насныхан нийт оролцогчдын 50 гаруй хувийг эзэлж байна. Сонгон судалсан ТВ-ийн “чат”-ын суваг нь сарын хугацаанд садар самуун явдлын талаарх хамгийн их буюу нийт 13560 минутын нэвтрүүлэг гаргасан байна. Гэхдээ ТВ чат нэвтрүүлгээр үргэлж садар самууныг сурталчилсан мессеж илгээгдээд байдаггүй ч нэвтрүүлгийн агуулгын 88,97% энэ талын агуулгатай байна гэдэг нь нотолгоо болох хангалттай тоо баримт болж байна.

Ажиглалтын хугацаанд сонгон авсан ТВ-ын “чат”-ын сувгаар хамгийн их садар самууныг сурталчилсан нийт 96 мессеж илгээгдсэнээс хүйсийн хувьд авч үзвэл эрэгтэйчүүд илүү давамгайлсан буюу нийт оролцогчдын 77,1%-ийг эзэлж, эмэгтэйчүүд 19.8%-ийг эзэлж байна. Энэ “чат”-ад мессеж явуулж байгаа оролцогчдыг насны хувьд /зөвхөн насаа тодорхой тавьсан мессежийг авч үзэв /авч үзвэл ихэнх нь буюу 50 гаруй хувь нь 14-24 насныхан байв.

Мессеж явуулсан нийт судалгаанд оролцогчдыг гар утасны төлбөрийн хэлбэрээр нь авч үзвэл 70% нь картын хэрэглэгчид байсан. Дараа төлбөрт хэрэглэгчдийн явуулсан мессеж 25%-ийг эзэлж байснаас гадна эдгээр хэрэглэгчдийн илгээсэн мессежинд нь ажиглалт хийж үзвэл ихэнх нь санхүүгийн тусламж үзүүлж, охидтой танилцахыг хүссэн байсан нь бас анхаарал татаж байлаа. 5% нь дугаараа нууцалсан хүмүүс байв.


Ижил хүйстэнтэйгээ явалдана гэсэн буюу гомо, лесби хамтрагчаа хайсан мессеж 4,16%-ийг эзэлсэн. Хэдийгээр өнөөдөр хүн эрхээ эдэлж, эрх чөлөөтэй болсон хэдий ч эрээ цээрээ алдсан мессеж нь бидний өсвөр

үеийнхний бэлгийн баримжаалалд тодорхой нэг хэмжээгээр нөлөөлөхийг үгүйсгэх аргагүй юм. Ямар нэгэн зүйл амласан, өөрийгөө рекламдсан мессеж 13 буюу 13,5%-ийг эзэлж байна.

Биеэ үнэлэгч авна гэж мессеж илгээсэн эрэгтэйчүүд 5,2%-ийг, биеэ үнэлнэ гэж мессеж явуулсан эмэгтэйчүүд 4,2%-ийг эзэлж байна. Онгон охинтой унтах гэсэн мессеж 1,04% байна. Бусад садар самуун үг хэллэг ашигласан мессеж 2,1%-ийг эзэлж байна.

Чатуудын цаана хүний наймаа эрхлэгчид, хорон санаа өвөрлөгчид, гэмт хэрэгтнүүд ч байж болохыг үгүйсгэх аргагүй учир телевизүүд ийм төрлийн мессежийг нэвтрүүлэхгүй байх хэрэгтэй байна.

Дүрст зураг 5.
Сурталчилгааны агуулга



FM-ийн зар сурталчилгааны мэдээлэл нь нийт мэдээллийн 15,4%-ийг эзэлж байна. Зар сурталчилгааны мэдээллийн 93,1%-ийг эзэлсэн садар самуунд уриалах өнгө аястайгаар шөнөөр үйл ажиллагаа явуулдаг зочид буудал, диско баар, клубуудыг сурталчилж байна.

Эдгээр зар сурталчилгаа нь олон давтамжтай явагдаад зогсохгүй мөн садар самуун үг хэллэг, элдэв “дуу авиатайгаар” цацагддаг.

Садар самуун бүхий нийт мэдээллийн хурьцал үйлдсэн талаар ярьсан, үнсэлцэх үйлдлийг тайлбарлан ярьсан, садар самуун үг хэллэг ашигласан зэрэг нь тус бүр 3,7%, нүцгэн биеийн тухай дүрслэн ярьсан 4,3%, бусад 7,4%, эдгээр нь энгийн мэдээллийн шинжтэй ч цаад утга нь садар самуунд уриалах өнгө аястай мэдээллүүд 77,2% байна. FM радиод холбогдож байгаа хүмүүсийн ихэнх нь өсвөр насныхан байдаг учраас садар самуун явдлыг шууд ярихаасаа илүү түүнд уруу татсан өнгө аястай мэдээллүүдийг ихээр өгч байгаа нь ажиглагдсан болно.

Нэвтрүүлгүүдийн гол зорилго нь 4 оронтой утасны тарифыг өндөр гаргахад оршино. Энэ утсанд холбогдсон оролцогчид хамгийн бага нь 30 секунд, хамгийн их гэж тэмдэглэсэн тохиолдол нь 16 минут байсан ба дунджаар 2 минут

Зар сурталчилгааны тухай хуульд садар самуунд уруу татахад хүргэж болох агуулгатай зар сурталчилгааг бүтээх, түгээхийг хориглоно.

орчим холбогддог байна.

Садар самуун бүхий явдлыг /хурьцал үйлдсэн талаар ярьсан 66,7%, нүцгэн биеийн тухай дүрслэн ярьсан 42,9%, үнсэлцэх үйлдлийг тайлбарлан ярьсан 66,7%/ ихэвчлэн энгийн мэдээллийн хэлбэрээр сурталчилж байна. Садар самуун үг хэллэг нь ихэвчлэн шторкд агуулагдаж байна.

Садар самуун үг хэллэг дуунд маш ихээр агуулагдаж байгаа нь FM радиогоор цацагдаж байгаа рэп, хип хоп урсгал чиглэлээр дуулдаг хамтлаг дуучдын дууны үгнээс харж болно. Хамтлагийн дуунууд ямар ч хяналтгүй садар самууныг сурталчилсан үг, дуу авиаг түлхүү оруулж өгсөн байгаа нь энэ чиглэлийн дуу хөгжмийг өсвөр үеийнхэн хамгийн их сонирхож сонсдог учраас шууд нөлөөлж байна. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд хүүхдийг садар самуунд татан оролцуулах, түүнчлэн садар самууныг сурталчлахад ашиглахыг хориглохоос гадна ийм үйлдэл хийхээс хамгаалах, сэргийлэх, хүүхэд байдаг орчинд эдгээр үйл ажиллагааг нэвтрэхээс сэргийлэх зэрэг хэм хэмжээг тусгасан байна.

Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд хүүхдийг садар самуунд татан оролцуулах, түүнчлэн садар самууныг сурталчлахад ашиглахыг хориглохоос гадна ийм үйлдэл хийхээс хамгаалах, сэргийлэх, хүүхэд байдаг орчинд эдгээр үйл ажиллагааг нэвтрэхээс сэргийлэх зэрэг хэм хэмжээг тусгасан байна

ДҮГНЭЛТ

Садар самуун явдалтай тэмцэх хууль батлагдаж эрх зүйн нөхцөл хэдийгээр бий болсон ч нийгэмд энэ үзэгдэл буурахгүй байгаагийн нэг том шалтгаан нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр энэхүү мэдээлэл нилээдгүй гарч байгаатай холбоотой байна гэсэн дүгнэлтийг өгч байна.

1. Сонинд гарч байгаа мэдээллийг агуулга, ач холбогдлын хувьд ангилалд оруулан судлахад, танин мэдэхүйн чанартай мэдээлэл харьцангуй бага хувьтай гарсан. Бэлгийн амьдралын талаарх энэхүү хоосон орон зайг зөв өнгө аястайгаар өгөх шаардлагатай нь гурван сонины аль алинд нь ажиглагдаж байлаа. Сонгож авсан тусгай хэрэгцээт болон чөлөөт сонины хувьд сэрэмжлүүлэх мэдээлэл гэдэгт хүчингийн хэрэгтэй холбоо бүхий мэдээллүүдийг нийтэлж байгаа ч энэхүү мэдээллүүд нь залуучуудад сонор сэрэмжтэй байхыг анхааруулах биш, хэтэрхий илтээр өгүүлж, эргээд гэмт хэрэг гарах нөхцлийг бүрдүүлж байгаа мэт сэтгэгдэл төрүүлж байлаа.

Ажиглалтад тулгуурлан бичигдсэн нийтлэл нь хамгийн өндөр буюу 37.8 хувьтай. Энэ нь статистик баримтад тулгуурласнаас 47 дахин, судалгааны материалд тулгуурлан бичигдсэнээс 1,5 дахин илүү байгаа нь мэдээллийн эх үндэс баталгаатай эх сурвалжаас авсан, мэдээллийн найдвартай байдал гэдгийг анхааралдаа авсан эсэхэд эргэлзээ төрж байсан юм. Уг эрээ цээргүй нийтлэлийн эзэн маань ямар нэг порно кино, сайтыг хараад тоочиж байгаа мэт сэтгэгдлийг судлаач бидэнд төрүүлж байсныг хэлэх нь зүйтэй.

Садар самууны холбогдолтой нийт мэдээллийн 48% нь бие эрхтнээ ил гаргасан хүүхний зураг нийтэлсэн бол, хурьцал үйлдэх болон үнсэлцэх озолцох үйлдлийн, бэлгийн амьдралын талаар маш нарийн дүрсэлсэн нь хэвлэл мэдээллээр садар самууныг шууд сурталчилсны тод жишээ юм. Харамсалтай нь иймэрхүү баримт нийтэлсний хойноос ямар нэг хариуцлага тооцсон, хууль эрх зүйн үүднээс шийтгэгдсэн баримт байхгүй байгаа нь уг хуулийн хэрэгжилтийн өнөөгийн байдлыг харуулж байна.

2. Ажиглалт хийсэн нэг сарын хугацаанд сонгож авсан телевизүүдийн хувьд ТВ-ийн “чат”-ын сувгаар садар самууныг сурталчилсан мэдээлэл 89%-ийг эзэлж байгаа нь анхаарлаа хандуулах цаг болсныг харуулж байна. Магадгүй чатны цаана хүний наймаа эрхлэгчид, хорон муу санаа өвөрлөгчид, гэмт хэрэгтнүүд ч байж болохыг үгүйсгэх аргагүй юм.

“Чат”-ын сувгууд нь орлого олохын тулд хэний ч, юуны ч тухай зарыг ямар ч хяналтгүйгээр дуртай үедээ цацаж байгаа нь садар самууныг сурталчлах индэр болж байна. Тухайлбал, нийт 7 телевиз ТВ чат нэвтрүүлгийг гаргадаг бөгөөд зөвхөн телевизийн “чат”-наас олж байгаа орлогыг тооцож үзвэл: ТВ чат нэвтрүүлэг нь өдөрт ойролцоогоор 8 цаг авдаг бөгөөд 1 цагт дунджаар 200 удаа ямар ч төрлийн хамаагүй мессеж нэвтрүүлдэг. Үүнийг үржүүлбэл өдөрт дунджаар 1600 мессеж телевизээр гарч байна гэсэн үг. ТВ “чат” хүлээн авч байгаа тусгай дугаар руу 1 мессеж илгээхэд 300 төгрөг ба үүнийг 1600-гаар үржвэл нийт 480000 төгрөг болох юм. Энэ нь тухайн телевиз зөвхөн хэдэн клип үзүүлж чат явуулснаар өдөрт дунджаар хагас сая төгрөгийг олж байгаа юм.

3. FM-ээр цацагдаж буй зар сурталчилгааны мэдээллийн дийлэнх хувь нь шөнөөр үйл ажиллагаа явуулдаг зочид буудал, клубуудын реклам байгаа нь садар самуунд уриалах шинжтэй байна.

FM радиогоор давтамжтайгаар цацагдаж буй садар самуун бүхий мэдээллүүдийн бүтцийг аваад үзвэл танин мэдэхүйн шинжтэй мэдээлэл хамгийн бага, харин шторк хамгийн их хувийг эзэлж байсныг судалгааны дүн харуулж байна. Эдгээр нь статистик тоо баримт, ажиглалт, судалгааны материалд тулгуурлаагүй мөн аль нэг мэдээ сурвалжлага, танин мэдэхүйн шинж чанартай мэдээллүүд биш зөвхөн хөтлөгчийн зүгээс FM-ийн сонсогчдод хандсан яриа, мэдээлэл, шторк, оролцогчидтой ярилцсан ярилцлага, зар сурталчилгааны мэдээлэл байдаг. Хөтлөгч нэвтрүүлгээ явуулж байх үедээ садар самуун өнгө аястай, ёс суртахуунгүй үг хэллэгийг байнга хэрэглэн оролцогчидтой ярилцаж, ямар ч дууны захиалгыг хязгаарлалтгүйгээр авч цацдаг байна.

FM радиогийн нэвтрүүлэгт холбогдсон оролцогчдын 91% нь өсвөр үеийнхэн байгааг радиогийнхан анхааралдаа авах шаардлагатай байна. Учир нь хөтлөгчийн зүгээс бэлгийн амьдралын талаар ярьж байгаа үг хэллэг, асууж буй асуултанд оролцогчид хариулж байгаа нь тухайн садар самуун өнгө аястай ярианд дургүйцсэн, татгалзсан, эвгүйцсэн хандлага гаргахгүй байгаа нь сонирхол татаж байсан. Үүнээс дүгнэн үзэхэд өсвөр насныхан мэдээллийг ямар ч шүүлтүүргүйгээр шууд хүлээж авдаг нь тэдний төлөвшилтөнд сөргөөр нөлөөлөх, нэг нэгийгээ уруу татах бололцоотойг харуулж байна.

4. Садар самуунтай тэмцэх тухай хууль гарчихаад байхад садар самуун явдал байсаар л байна. Энэхүү хууль бус үйл ажиллагаа далд байдалд зохион байгуулалттай шинжийг агуулж саун, массажны газар нэрийн дор үйлчилгээ үзүүлж буй газар олноор нээгдэж тэлэх, гэмт

этгээдүүд биеэ үнэлэгчдийг ашиг орлого олох хэрэгсэл болгон илүү олон охид, эмэгтэйчүүдийг татан оролцуулах зэрэг сөрөг үзэгдлүүд гарч байгаа тухай сонин хэвлэлээр нийтлэгдэж байна. Тухайлбал, Садар самууныг илтээр сурталчлах нөхцлийг бүрдүүлж өгсөн “Мона Лиза”, “Марко Поло”, “Тан Луу”, “Универсал маркетинг” зэрэг үйлчилгээний газрууд хуулийн тодорхой зүйл заалтыг илтээр зөрчсөн байгааг хууль хяналтын байгууллага тодорхойлчихсон байхад хэрэг нь өнөө болтол шийдэгдээгүй байгаа нь нэгэнт гарчихсан хуулийн хэрэгжилт ямар байгааг илтгэх нэг үзүүлэлт юм.

Үүнээс үүдэн зохион байгуулалттай гэмт хэрэг, бэлгийн хүчирхийлэл, ялангуяа хил дамжуулан хүн худалдах гэмт хэрэг гарах нөхцлийг бүрдүүлэх, ХДХВ/ДОХ зэрэг хүн амын болон Үндэсний аюулгүй байдалд нөлөөлөхүйц бэлгийн замын халдварт өвчин ихсэх зэрэг сөрөг үр дагавар гарч байна.

Энэ бүх үйлдлийн эцэст өсвөр үе ялангуяа охид, залуу эмэгтэйчүүд илүүтэй хохирсон байдаг тул эцэг эхчүүд, боловсрол соёлын байгууллага, нийгмийг гэгээрүүлэх үүрэг хүлээж байдаг хэвлэл мэдээллийнхэн өөрсдийн бодлогоо эргэж харахаар болжээ.

ЗӨВЛӨМЖ

Хэвлэл мэдээллийнхэнд

- Зар сурталчилгааны тухай хуульд садар самуунд уруу татахад хүргэж болох агуулгатай зар сурталчилгааг бүтээх, түгээхийг хориглодог ч “Ажлын”, “Танилцъя” зэрэг заруудад энэ төрлийн далд утгатай зарууд их байгааг анхааралдаа авах. Садар самуунд уруу татаж болзошгүй мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлэхгүй байх
- Сонины нэгэн буланд нэг удаагийн нийтлэлийг зөвхөн бэлгийн амьдралын янз бүрийн асуудалтай байгаа хүмүүст зөвлөгөө өгөх хэлбэрээр зориулах. Энэ мэтээр тусгай хэрэгцээт, өдөр тутмын, шар сонин гэсэн агуулгынхаа хүрээнд өөр өөрсдийн уншигчдын асуултад хариулах булантай болох.
- Телевизүүд садар самуунд уруу татсан мессеж илгээж байгаа хүмүүсийн мессежийг гаргахгүй байх. ТВ чат сувгаар гарч буй мэдээллийг эмх цэгцтэй хяналттай болгох.
- FM нь бусад хэвлэл мэдээллийн хэрэгслийг бодвол зөвхөн сонсож, яриа, ярилцлага, дуу, зар сурталчилгаа явуулах байдлаар

сонсогчдод хүрдэг учраас энэ нь нэг талаас хөтлөгчийн нүүр царай ил харагддаггүйгээс ичгүүр сонжуургүй, ёс зүйгүй үг хэллэг хэрэглэх, асуух зүйл нь сонин болон телевизийг бодвол илүү чөлөөтэй, хэрээс хэтэрсэн шинжтэй байгаа учраас хэвлэл мэдээллийн хэрэгслийн тэр дундаа радиогийн хөтлөгчийн ур чадвар, ёс зүйг дээшлүүлэх асуудал чухлаар тавигдаж байна. FM-ийн хөтлөгчийн ёс зүйн баримтлах хэм хэмжээг боловсруулах, мөрдүүлэх

- Телевизийн чат сувагт ихэвчлэн эрэгтэй оролцогчид давамгайлж охид, залуу эмэгтэйчүүдийг бэлгийн харилцаанд дуудаж байгааг богино долгионы радиод эрэгтэй хөтлөгчийн үг хэллэгээс эмэгтэй оролцогчид илүүтэй холбогдож байгаа нь сонирхол татаж байгаа тул цаашид гүнзгийрүүлэн учир шалтгаан, хүчин зүйлийг судлах

Төр засгийн болон хууль хяналтын байгууллагынханд:

1. Эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зайлшгүй шаардлагатай байгааг дараах чиглэлээр авч үзэх хэрэгтэй гэж үзэж байна. Үүнд:

- Тухайн үед шаардлага хангаж байсан боловч өнөө үед шаардлагагүй болсон харилцааг халах, эсхүл оновчтой, тодорхой бус, дутуу, ойлгомжгүй байгаа харилцааг сайжруулах, хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах
- Нийгмийн болон эрх зүйн шинэ харилцаанд тохирсон, олон улсын чиг хандлагыг харгалзсан, хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн харилцааг шинээр нэмж тусгах. Хууль бус үйлдлийг хийхэд нөлөөлж буй хүчин зүйлийг илрүүлж холбогдох этгээдүүдэд хариуцлага тооцох
- Садар самуун явдалтай тэмцэх, түүнд хяналт тавих механизмуудыг шинээр хуульчилж бүрдүүлэх
- Хэвлэл мэдээллийн хэрэгслээр садар самуунд уруу татсан мэдээллүүдийн цацагдаж байгаад хяналт тавих, хуулийг зөрчиж байгаа хэвлэл мэдээллийн хэрэгслийн байгууллагуудад зохих хууль журмын дагуу хариуцлага тооцох шаардлагатайгаас үзвэл зарим ТВ болон FM-ийн сувгийн үйл ажиллагааг хаах
- ФМ, Телевизийн мэдээллээс /чатнаас/ болж хүний амь нас, эд хөрөнгө хохирлоо гэхэд хариуцах хариуцлага тооцох механизмыг бий болгох

- Олон нийтэд зориулсан хэвлэл мэдээллийн зарим хэрэгслийн нийтлэл, нэвтрүүлэг, зар сурталчилгаанд дүн шинжилгээ хийж дахин мэргэжлийн үнэлгээ хийх
- Хэвлэл мэдээллийн хэрэгслийн ажилтнуудын ёс зүйн хэм хэмжээг тогтоох, чанд мөрдүүлэх, хяналт тавих, хариуцлага тооцох
- Садар самуунтай тэмцэх талаар сургалт сурталчилгааг сайжруулах, үүнд ялангуяа хэвлэл мэдээллийн ажилтнуудыг өргөнөөр хамруулах,

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
6-р хороо, Багатойруу, 44-р байр, 4 тоот

Утас/Факс: 976-11-317904

И-мэйл: mones@mongol.net

Вебсайт: www.mones.org.mn

Монгол улс, Улаанбаатар-46А,

Шуудангийн хайрцаг-280